



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАРАГТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 16/02

Тарагт сум

Сумын 2024 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 28/14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Тарагт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын 2024 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн, хэмжээг дор дурдсанаар баталсугай. (мянган төгрөг)

1.	Сумын төсвийн орлого бүгд	Орлогын дүн
1.1.	Татварын орлого	213,800.0
1.1.1.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	16,200.0
1.1.2.	Суутганы татвар	198,000.0
1.1.3.	Бууны албан татвар	1,000.0
1.1.4.	Улсын тэмдэгтийн хураамж	1,200.0
1.1.5.	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.0
1.1.6.	ҮХХөрөнгө борлуулсны орлого	2,400.0
1.1.7.	Газрын төлбөр	17,000.0
1.1.8.	ҮХХАТатвар	2,500.0
1.1.9.	Нохойны татвар	500.0
1.1.10.	Татварын буцаалт	(31,000.0)
1.2.	Сумын төсвийн татварын бус орлого	40,300.0
1.2.1.	Торгуулийн орлого	15,800.0
1.2.2.	Хадгаламжийн хүүгийн орлого	10,850.0
1.2.3.	Газрын тосны орлого	9,300.0
1.2.4.	Орон нутгийн өмч хөрөнгийг ашигласны төлбөр (15%)	4,350.0
Нийт дүн		254,100.0

Хоёр. Сумын 2024 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг хавсралтаар баталсугай:

(мянган төгрөг)

д/д	ТЭЗ, түүний харьяа байгууллага	Орлогын дүн
2.1	Засаг дарга	
2.1.1	Төсвийн байгууллагын өөрийн орлого	300.0

Гурав. Сумын 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 2,409,071.8 (хоёр тэрбум дөрвөн зуун есөн сая далан нэгэн мянга найман зуу) мянган төгрөгөөр баталж төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

		/мянган төгрөг/
3.1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	227,970.4
3.1.1	Урсгал зардлын дээд хэмжээ Үүнээс: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	211,598.4
3.1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	3,600.0
3.1.3	Мэдээлэл сурталчилгааны зардал	150.0
3.1.4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	9,922.0
3.1.5	БИНХурлын даргын урамшуулал	2,700.0
3.2	Засаг дарга	1,032,077.0
3.2.1	Сумын Засаг даргын Тамгын газар	1,032,077.0
3.2.1.1	Урсгал зардал	735,970.6
3.2.1.2	Орон нутгийн нөөц хөрөнгө	40,000.0
3.2.1.3	Багийн захиргаа	201,504.4
3.2.1.4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	28,702.0
3.2.1.5	Хур хог хаягдал, орчны бохирдлыг цэвэрлэх үйлчилгээ	6,000.0
3.2.1.6	Улсын баяр наадам	15,000.0
3.2.1.7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	2,400.0
3.2.1.8	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал	2,500.0
3.3	ТЗШ байгууллагуудын тогтмол зардал	389,271.0
3.3.1	ЕБСургуулийн тогтмол зардал	210,277.0
3.3.2	Туяа бага сургуулийн тогтмол зардал	10,100.0
3.3.3	Эрүүл мэндийн төвийн тогтмол зардал	48,948.0
3.3.4	СӨББайгууллагийн тогтмол зардал	41,846.0
3.3.5	Соёлын төвийн тогтмол зардал	78,100.0
3.4	Орон нутгийн хөгжлийн сан	535,691.4
3.5	Сум хөгжүүлэх сан	124,062.0
3.6	Эрсдэлээс хамгаалах сан	100,000.0

Дөрөв. Сумын 2024 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 535,691.4 (таван зуун гучин таван сая зургаан зуун ерэн нэг мянга дөрвөн зуу) мянган төгрөгөөр баталсугай.

Тав. Сумын төсвөөс аймгийн төсөвт татан төвлөрүүлэх орлогын хэмжээг 16,724.5 (арван зургаан сая долоон зуун хорин дөрвөн мянга таван зуу) мянган төгрөгөөр баталсугай

Зургаа. Сумын төсвийн 2024 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,409,071.8 (хоёр тэрбум дөрвөн зуун есөн сая далан нэгэн мянга найман зуу) мянган төгрөг буюу дор дурдсанаар баталсугай.

6.1 Сумын татварын болон татварын бус орлого 254,100.0 (хоёр зуун тавин дөрвөн сая нэг зуун мянга) мянган төгрөг;

6.2 Сумын төсөвт Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,321,269.1 (нэг тэрбум гурван зуун хорин нэгэн сая хоёр зуун жаран есөн мянга) мянган төгрөг;

6.3 Сумын төсвийн урьд оны үлдэгдэл 89,649.3 (наян есөн сая зургаан зуун дөчин есөн мянга гурван зуу) мянган төгрөг

6.4 Сумын Засаг даргын Тамгын газрын өөрийн орлого 300,0 (гурван зуун мянга) мянган төгрөг

6.5 Сумын орон нутгийн хөгжлийн сангийн он дамжих үлдэгдэл 140,000.0 (нэг зуун дөчин сая) мянган төгрөг

6.6 Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 312,497.5 (гурван зуун арван хоёр сая дөрвөн зуун ерэн долоон мянга таван зуу) мянган төгрөг

6.7 Малын тоо толгойн албан татвар 83,193.9 (наян гурван сая нэг зуун ерэн гурван мянга есөн зуу) мянган төгрөг

6.8 Хоршоо хөгжүүлэх сангийн он дамжих үлдэгдлийг 70,000.0 (далан сая) мянган төгрөг, зээлийн хүүгийн эргэн төлөлтийг 54,062.0 (тавин дөрвөн сая жаран хоёр мянга) мянган төгрөг, нийт 124,062.0 (нэг зуун хорин дөрвөн сая жаран хоёр мянга) мянган төгрөг

6.9 Эрсдэлээс хамгаалах санд орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт 16,000.0 (арван зургаан сая) мянган төгрөг, сангийн орлого 84,000.0 (наян дөрвөн сая) мянган төгрөг, нийт 100,000.0 (нэг зуун сая) мянган төгрөг

Долоо. "Сумын төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлт"-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Найм. "Сумын Орон нутгийн хөгжлийн сангаар 2024 оны хуваарилалт"-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Ес. "Сум хөгжүүлэх сангийн 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

Арав. Эрсдэлээс хамгаалах 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг 5 дугаар хавсралтаар баталсугай.

Арван нэг. "Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ"-ний зардлыг 6 дугаар хавсралтаар баталсугай.

Арван хоёр. Сумын Засаг даргад (З. Түмэндэмбэрэл)-д даалгах нь:

13.1. Батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу хэрэгжүүлсүгэй.

13.2. Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай хэрэгжүүлж, орлогыг бүрэн төвлөрүүлэн зарлага санхүүжилтийг гүйцэтгэж байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай.

13.3. Төсвийн сахилга хариуцлагыг сайтар ханган ажиллаж, төсвийн гүйцэтгэлд төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэн өгсөн дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлж ажилсугай.

ДАРГА



Ц. ОДОНТУЯА



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 2 дугаар сарын 13-ны
өдрийн 16 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАМГАРХ
ЧАНАРЫН БОЛОН ТОО ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

№	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр	Хөтөлбөрийн хүрэх үр дүн	Үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2024 оны зорилтот түвшин	Хөтөлбөрийн зарцуулах төсөв
(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)	(8)	(9)
1. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЕСНЫ БАЙГУУЛЛАГА								
1.1	70105 -Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл үндсэн ажиллагаа	Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардал нь байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хэвийн явуулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаануудын чанар үр нөлөөг дээшлүүлэх, төлөөлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд бүхий л талын дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хуулиар олгогдсон чиг үүргүүдээ ханган, орон нутгийн хөгжлийн бодлогыг оновчтой тодорхойлон ажиллах. Нутгийн өөрөө удирдах байгууллагын оюуны болоод материаллаг нөөц хэрэгслийн хангамжийг	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал улиралд нэг удаа, Тэргүүлэгчдийн хурал сард 2 удаа, хороодын бусад хуралдаануудаас шалтгаалан тухай бүрд хуралдаж, санал дүгнэлт гаргасан байна. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт өмнөх оноос өссөн байна. Хэрэгжилтийг тооцох аргачлалыг сайжруулсан байна. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн дээшилж, иргэдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоо нэмэгдсэн байна	Мян /төг/	2023	146,678.3	211,598.4	211,598.4

	нэмэгдүүлэх, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааг хэвийн явуулахад оршино.								
1.2	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	80802-Засгийн газрын хөдөөгийн сэргэлт бодлогын хэрэгжилт хангагдана. Байгууллагын дотоод журмын дагуу албан хаагчдын хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах,ажил үйлчилгээний чанар,үр дүнг дээшлүүлэх,ажлын өндөр амжилт гаргаж бусдыгаа манлайлсан ажилчдын шагнал урамшуулал болон нэг удаагийн тэтгэмж олгоход зарцуулагдана	Суманд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг дэмжиж, ур чадвар дээшилж,ажлын бүтээмж дээшилнэ. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, 5 жил тогтвор суурьшилтай төрийн захиргааны албан тушаалд ажилласан албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж олгоно. Мөн иргэдийн хүсэлтийг үндэслэн буцалтгүй тусламж үзүүлэх	Мян /төг/	2023	340.0	9,922.0	9,922.0	
1.3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөд	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.3-т заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухайн нутаг дэвсгэрт зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг санхүүжүүлснээр сумын хэмжээний гэмт хэргийн гаралтыг бууруулах, иргэдийн амар тайван байдлыг хангахад	Иргэдийг тав тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн дэг журам хангадсан байна. Гэмт хэргийн гаралтын тоо буурна.	Мян /төг/	2023	6,000.0	3,600.0	3,600.0	3,600.0

	зориулагдана. ажиллуулах								
1.4	Мэдээлэл сурталчилгааны арга хэмжээний зардал нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, олон нийт, иргэдэд мэдээлэх ажлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан гүйцэтгэх	Иргэдийн санал бодлыг судалж, тэдний оролцоонд тулгуурлан нээлттэй хэлэлцүүлгүүд тогтмол хийгдэн гарсан санал санаачлагууд шийдвэрт тусгагддаг болно. Хурлын үйл ажиллагааны талаар иргэд тогтмол мэдээлэлтэй байна.	Мян /Төг/	2023	0	150.0	150.0		150.0
1.5	БИНХурлийн дарга нарын урамшуулал		Мян /Төг/	2023	2,025.0	2,700.0	2,700.0		2,700.0
2. ОРОН НУТГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛЫН УДИРДАГА									
2.1	Үндсэн ажиллагаа үйл	Сумын эдийн засаг нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлж, төрийн захиргааны байгууллагын үйлчилгээний манлайллыг хангана.	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх	Мян /Төг/	2023	448,926.1	735,970.5		735,970.5
2.2	Орон нутгийн нөөц сан	Байгалийн давагдашгүй хүчин зүйл, сум орны болон иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулсан байна.	Сумын Засаг даргын нөөц санг батлагдсан журмын дагуу, батлагдсан төсвийн хүрээнд, санхүүгийн зөрчилгүй зарцуулах, Гамшгаас хамгаалах, эрсдлийг бууруулахад нөөц сангийн 30 хүртэлхи хувийг зарцуулахаар төлөвлөж хэрэгжүүлэх	Мян /Төг/	2023	53,000.0	40,000.0		40,000.0
2.3	Багийн дарга Засаг	Засаг захиргааны анхан шатны нэгж багт төрийн	БИНХ-ыг хуулийн хугацаанд хуралдуулах, багийн иргэдээр удирдамжийн дагуу тойрох	Мян /Төг/	2023	119,644.5	201,504.4		201,504.4

		үйлчилгээг түргэн шуурхай хүргэсэн байна.	ажлыг ИТХ, ЗДТГ-тай хамтран зохион байгуулах, багийн иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх, сум орон нутгаас зохион байгуулсан нийтийг хамарсан арга хэмжээнд багийн иргэдийг бүрэн оролцуулсан байна.					
2.4	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар тухайн жилийн төсөвт батлагдсан хөрөнгийг үр ашигтай зарцуулах	ИТХ-аар батлагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд төлөвлөсөн ажлыг батлагдсан төсвийн хүрээнд үр дүнтэй бүрэн хэрэгжүүлсэн байна.	Мян /төг/	2023	2,854.3	2,500.0	2,500.0
2.5	Улсын их баяр наадам	82801-Тулгар төрийн 2229, Их Монгол улс байгууллагдын 814 жил, Ардын хувьсгалын 99 жилийн ойг тэмдэглэх	Ардын хувьсгалын 101 жилийн ойг сумын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлсэн байна.	Мян /төг/	2023	10,000.0	15,000.0	15,000.0
2.6	Хог хаягдал устгах	82212-Хог хаягдал, хортон мэрэгчидийг устгах	Хог тээврийн машины жолоочийг гэрээний үндсэн дээр цалинжуулж, айл өрхийн хог хаягдлыг хуваарийн дагуу ачиж, буулган орчны бохирдлыг бууруулсан, хүний эрүүл мэндийг хамгаалсан, төв суурингийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Мян /төг/	2023	6,000.0	6,000.0	6,000.0
2.7	Ажил олгогчоос олгох тэтгэмж	80802-Засгийн газрын хөдөөгийн сэргэлт бодлогын хэрэгжилт хангагдана. Байгууллагын дотоод журмын дагуу албан хаагчдын хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах, ажил үйлчилгээний чанар, үр дүнг дээшлүүлэх, ажлын өндөр амжилт гаргаж	Суманд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг дэмжиж, үр чадвар дээшилж, ажлын бүтээмж дээшилнэ. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, 5 жил тогтвор суурьшилтай төрийн захиргааны албан тушаалд ажилласан албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж олгоно. Мөн тэтгэвэрт гарсан 1 албан хаагчид тэтгэмж олгоно.	Мян /төг/	2023	2,000.0	28,702.0	28,702.0

		бусдыгаа манлайлсан ажилчдын шагнал урамшуулал болон нэг удаагийн тэтгэмж олгоход зарцуулагдана							
2.8	Гэмт хэргээс урьдчилан сэрийлэх зөвлөд	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухайн нутаг дэвсгэрт зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг санхүүжүүлснээр сумын хэмжээний гэмт хэргийн гаралтыг бууруулах, иргэдийн амар тайван байдлыг хангахад зориулагдана. ажиллуулах	Иргэдийг тав тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн дэг журам хангагдсан байна. Гэмт хэргийн гаралтын тоо буурна.	Мян /Төг/	2023	6,000.0	3,600.0	3,600.0	
3. ТӨРИЙН ӨМЧИЙН БАРИЛГЫН ТОГТМОЛ ЗАРДАЛ									
3.1	Үүнд: Соёлын төвийн тогтмол зардал ЕБС-ийн тогтмол зардал ЭМТ-ийн тогтмол зардал СӨББ-ын тогтмол зардал	Байр сайжруулан ажилтануудын тох тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Төсвийн байгууллагуудад байр ашиглалттай холбоотой зардалуудыг бүрэн санхүүжүүлж, халаалтын хэмнэлтийн горим тогтоох, дулааны алдагдалыг багасгаж ажиллана.	Мян /Төг/	2023	320,891.1	389,271.0	389,271.0	
4. ТУСГАЙ САНГУУД									
4.1	Хоршоо хөгжүүлэх сан	Тусгай сангуудыг зориулалтын дагуу санхүүгийн зөрчилгүй журмын дагуу.	Хоршоо, аж ахуй нэгжийг зээлийн бодлогоор дэмжин, иргэдийн хамтын хөдөлмөрийг хорших, тэдгээрийн үйл	Мян /Төг/	2023	192,000.0	124,062.0	124,062.0	

	батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.	ажиллагааг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж ажиллана. Зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж, сангийн журмын талаар иргэдэд мэдээлэл сургалт сурталчилгааг хийсэн байна.						
Эрсдэлээс хамгаалах сан		Байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах, хяналт шалгалт хийх, гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх, байгалийн гамшигт үзэгдлээс урьчилан сэргийлэх, түүнийг даван туулах, хохирлыг барагдуулах	Мян /төг/	2023	80,000.0	100,000.0	100,000.0	100,000.0
Орон нутгийн хөгжлийн сан		Иргэдийн санал санаачлага дээр тулгуурлан хөрөнгө оруулалтыг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлж, хөрөнгө оруулалт бүрэн хийгдсэн байна.	Мян /төг/	2023	365,182.7	535,691.4	535,691.4	535,691.4

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
хуралдааны 2023 оны 12 сарын 13-ны өдрийн
16/02 дугаар тогтоолын хавсралт

**ТАРАГТ СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

(мян. төгрөг)

Д/д	Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хамрах салбар	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих
1	2	3	4	5	6
1. Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ					
1.1	ЗДТГазар хүндэтгэлийн танхим	Төрийн үйлчилгээ	2023-2024	20,000.00	20,000.00
1.2	Цэцэрлэгийн гадаах тоглоом	Боловсрол	2023-2024	11,300.00	3,390.00
1.3	ЕБСургуулийн дотор сантехник	Боловсрол	2023-2024	50,000.00	47,210.00
1.4	Гэрэлтүүлэг	Төрийн үйлчилгээ	2023-2024	6,000.00	2,000.00
1.5	Хайсан хашаа	Байгаль орчин	2023-2024	20,000.00	4,000.00
1.6	Сэг зэм устгал	Байгаль орчин	2024	6,000.00	6,000.00
Нийт дүн					82,600.00
2. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ					
2.1	Наадмын талбай шинээр барих	1	2024	150,000.00	150,000.00
2.2	Сумын төвийн гэрэлтүүлэг, камержуулалт нэмэгдүүлэх	2	2024	50,000.00	50,000.00
2.3	Нийтийн халуун ус барих	3	2024	120,000.00	120,000.00
2.4	Багийн соёлын төвийн их засвар	4	2024	10,000.00	8,397.50
2.5	Соёлын төвийн тайз	5	2024	38,500.00	38,500.00
2.6	Багийн Соёлын төвийн цахилгааны эх үүсвэр Алтан тал, Их булаг, Урт	6	2024	3,000.00	3,000.00
Нийт дүн					369,897.50
3. Малын тоо толгойн албан татвар					
3.1	Малын эрүүл мэндийг хамгаалах	1	2024	27,193.90	27,193.90
3.2	Мал угаалгын ванн барих	2	2024	27,000.00	27,000.00
3.3	Мал угаалгын ванны хайсан хашаа Урт баг	3	2024	3,000.00	3,000.00
3.4	Алтан тал 2, Туяа 1 худаг засварлах	4	2024	8,000.00	8,000.00
3.5	Малын тэжээл тариалах	5	2024	18,000.00	18,000.00
Нийт дүн					83,193.90

Нийт зардлын дүн				535,691.40
1	Он дамжих үлдэгдэл	1	2024	140,000.00
2	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт	2	2024	312,497.50
3	Малын хөлийн албан татвараас	3	2024	83,193.90
Санхүүжилтийн дүн				535,691.40

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 13-ны
16/22 өдрийн тогтоолын гуравдугаар хавсралт



ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжигдэх дүн
		Эхлэх	Дуусах		
1	Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт	2024	2024	120,000.00	120,000.00
2	Хяналтын зардал	2024	2024	700.00	700.00
3	Бичиг хэрэг	2024	2024	216.00	216.00
4	Шуудан холбоо	2024	2024	336.00	336.00
5	Шатахуун	2024	2024	260.00	260.00
6	Мэргэжилтний урамшуулал	2024	2024	650.00	650.00
7	Програмын лицензийн төлбөр	2024	2024	460.00	460.00
8	Томилолт	2024	2024	730.00	730.00
9	Сургалтын зардал	2024	2024	710.00	710.00
10	Нийт дүн	2024	2024	124,062.00	124,062.00

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 13-ны
16/2 өдрийн тогтоолын дөрөвдүгээр хавсралт



ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжигдэх дүн
		Эхлэх	Дуусах		
1	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх	2024	2024	100,000.0	100,000.0
2	Нийт дүн	2024	2024	100,000.0	100,000.0

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 13-ны
16/12 өдрийн тогтоолын тавдугаар хавсралт



БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

(мянган төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжигдэх дүн
		Эхлэх	Дуусах		
1	Томоохон голын дагуух хөрс, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг зохион байгуулах	2024	2024	2,000.0	2,000.0
	Байгаль орчны багц хууль тогтоомж, дүрэм журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, тооллого, судалгааны ажил зохион байгуулах	2024	2024	500.0	500.0
2	Нийт дүн				2,500.0